

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/225 дугаар захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдааг цахим хэлбэрээр /интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

1. Дуудлага худалдааны хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу дараах 2 байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдаа явагдана.

I. Сүмбэр сум 3 дугаар багт авто замын зүүн талд, “Амтат зоог” зоогийн газраас урагш 0,15 га /1500м²/ газрыг зоогийн газар, зочид буудлын зориулалтаар

II. Сүмбэр сум 2 дугаар багт М-Ойл ХХК-ий Шатахуун түгээх станцын зүүн талд 0,24 га /2400м²/ газрыг худалдаа, үйлчилгээний зориулалтаар тус тус зарлаж байна.

2. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван таван/

3. Анхны үнэ: 1-р байршил 6000000 /Зургаан сая/

2-р байршил 19200000 /Арван есөн сая хоёр зуун мянга/ төгрөг

4. Дэнчин: 1-р байршил 600000 /Зургаан зуун мянган/ төгрөг

2-р байршил 1920000 /Нэг сая есөн зуун хорин мянган/ төгрөгийг 100220029002 дансанд тушааж баримтыг хавсаргана.

5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг 100220500941 дансанд тушаасан байх.

6. Гэрээний зүйл: Сүмбэр сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.

7. Цахим хуудас: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар нэвтэрч оролцоно.

8. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа: Дуудлага худалдаанд оролцогчдыг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 08 цаг 30 минут хүртэл ажлын цагаар бүртгэж, баталгаажуулна.

9. Дуудлага худалдаа эхлэх: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагаас эхлэнэ.

10. Дуудлага худалдаа явагдах хугацаа: 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 17:00 цаг хүртэл тасралтгүй үргэлжилнэ.

11. Дуудлага худалдаанд ялагчийг тодруулах журам: Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн, өөрийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварын тухай мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.

12. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:

X=298785.439 Y=5138131.883
X=298807.113 Y=5138086.823
X=298780.149 Y=5138073.673
X=298758.476 Y=5138118.731



X=297884.3757 Y=5138851.7337
X=297937.7480 Y=5138873.7032
X=297944.9876 Y=5138826.2547
X=297902.8607 Y=5138809.1806



13. Техникийн нөхцлүүд: Цахилгаан болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцлүүд авагдсан болно.

14. Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем, техникийн нөхцөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг аймгийн ГХБХБГ-ын 104 тоот өрөөнд өгч байна.

Холбоо барих утас: 70543023, 99665607, 99549278.